



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/АЗ.

Булган сум

### Шагнаж, урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ахмад настны тухай хуулийн 12.1, 12.4 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үзэсгэлэн болгогч хэмээх Харагчин туулай жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан ахмад настнуудын нийгмийн хамгааллыг сайжруулж, ажил үйлсээрээ бусдыгаа манлайлан ажилласан “Тэргүүний ахмад”, “Ахмадад ээлтэй байгууллага”, “Шилдэг ахмадын хороо”-г шалгаруулсугай.

2. Аймгийн “Тэргүүний ахмад”, “Ахмадад ээлтэй байгууллага”, “Шилдэг ахмадын хороо”-г шалгаруулахад шаардагдах 698,000 (зургаан зуун ерэн найман мянга) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Аймгийн “Тэргүүний ахмад”, “Ахмадад ээлтэй байгууллага”, “Шилдэг ахмадын хороо”-оор шалгарсан ахмад настан, байгууллага хамт олныг шалгаруулах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
02 дугаар сарын 09-ний өдрийн А/13 дугаар  
захирамжийн хавсралт



Аймгийн “Тэргүүний ахмад” болон “Шилдэг ахмадын хороо”, “Ахмадад ээлтэй байгууллага”-аар шалгарсан ахмад настан, байгууллага хамт олонд олгох шагнал, урамшуулал олгох төсөв

Д/д	Зардлын нэр	Байгууллага хүний тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1.	2022 оны тэргүүний ахмад настан Д.Тоймаа	1 хүн	100,000	100,000
2.	Ахмадад ээлтэй байгууллагаар шалгарсан - Бугат сумын ЗДТГ, - Хутаг-Өндөр сумын “Гурванборхууд” ХХК, - Орхон сумын ЭМТ	3 байгууллага	100,000	300,000
	Аймгийн шилдэг ахмадын хороо - Гурванбулаг сумын ахмадын хороо	1 байгууллага	150,000	150,000
3.	Өргөмжлөл, жаазтай	A4-1	20,000	20,000
		A3-4	32,000	128,000
<b>Нийт дүн</b>			<b>698,000</b>	